



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Ач Анагаах Ухааны их сургууль

Хөтөлбөрийн нэр: Нүүр ам судлал

Индекс: D091101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ж.Үржинлхам

Гишүүд: Д.Уранчимэг

Д.Энхцэцэг

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	11
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	14
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	16
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	20
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	24
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	27
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	31
I. Багш нарын нэрс	31
II. Оюутнуудын нэрс	32
III. Ажил олгогчдын нэрс.....	33
IV. Төгсөгчдийн нэрс	33
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	34
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

<u>Ач АУДС</u>	“Ач” Анагаах ухааны дээд сургууль
<u>Ач АУИС</u>	“Ач” Анагаах ухааны их сургууль
<u>АУД</u>	Анагаах ухааны доктор
<u>АУМ</u>	Анагаах ухааны магистр
<u>АШУД</u>	Анагаахын шинжлэх ухааны доктор
<u>БНСУ</u>	Бүгд Найрамдах <u>Солонгос Улс</u>
<u>БНХАУ</u>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<u>БСШУЯ</u>	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
<u>БШУЯ</u>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<u>ДЭМБ</u>	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
<u>МАУБХ</u>	<u>Монголын анагаах ухааны боловсролын холбоо</u>
<u>МУАУ</u>	<u>Монголын уламжлалт анагаах ухаан</u>
<u>МҮНС</u>	Монголын үндэсний номын сан
<u>МШМХ</u>	Монголын мэргэжлийн шүдний холбоо
<u>НАС</u>	Нүүр ам судлал
<u>НАСС</u>	Нүүр ам судлалын сургууль
<u>НАЭ</u>	Нүүр амны эмчилгээ
<u>НАСЗ</u>	Нүүр амны согог засал
<u>НАЭТ</u>	Нүүр амны эмнэлзүйн тэнхим
<u>НАМЗ</u>	Нүүр амны мэс засал
<u>ОХУ</u>	Оросын Холбооны Улс
<u>ӨМӨЗО</u>	Өвөр <u>Монголын Өөртөө Засах Орон</u>
<u>СБЗА</u>	Сургалтын бодлого зохицуулалтын алба
<u>ХНАЭ</u>	Хүүхдийн нүүр амны эмчилгээ
<u>ХНАГЗ</u>	Хүүхдийн нүүр амны гажиг засал
<u>ХНАМС</u>	Хүүхдийн нүүр амны мэс засал
<u>ХНАЭТ</u>	Хүүхдийн нүүр амны эмчилгээний тэнхим
<u>ЭМАШТ</u>	Эрүүл мэндийн анхан шатны тусламж
<u>ЭМШУИС</u>	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
<u>ЭМЯ</u>	Эрүүл мэндийн яам

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Ач анагаах ухааны их сургууль Ach medical university	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Нүүр ам судлал	
Индекс	D091101	
Шинжээчид	<p>Шинжээчийн багийн ахлагч:</p> <p>Ж.Үржинлхам - Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн Нүүр амны эмчилгээний тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор</p> <p>Шинжээчийн багийн гишүүд:</p> <p>Д.Уранчимэг- Этүгэн их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн Нүүр амны мэс заслын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор</p> <p>Д.Энхцэцэг – Монгол Улсын Боловсролын их сургуулийн Багшийн сургуулийн дэд профессор, доктор</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа – Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.12.8	Урьдчилсан үнэлгээний тайланг сургуульд хүргүүлсэн.
	2021.12.16 – 12.17	Сургууль дээр ажиллаж, оролцогч талуудтай уулзаж, нотлох баримтуудтай танилцсан.
	2022.01.17	Шинжээчийн багийн тайланг БМИҮЗ-д хүргүүлсэн.
	2022.01.19	Шинжээчийн тайланг БМИҮЗ-ийн мэргэжилтэн сургуульд хүргүүлж, сургуулийн саналыг авсан.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Ач анагаах ухааны их сургууль 1998 онд АЧ Анагаах ухааны дээд сургууль нэртэйгээр үүсгэн байгуулагдсан хувийн хэвшлийн анхны анагаахын сургууль бөгөөд 2014 онд Боловсрол Шинжлэх Ухаан Спортын яамны шийдвэрээр их сургуулийн ангилалд шилжсэн байна. Байгууллагын магадлан итгэмжлэлд анх удаа 2005 онд 5 жилийн хугацаатай, 2011 онд 2 дахь удаагаа 10 жилээр тус тус магадлан итгэмжлэгдсэн. Тус сургууль Анагаах ухаан, Уламжлалт анагаах ухаан, Нүүр ам судлал, Нийгмийн эрүүл мэнд, Сувилахуйн чиглэлээр бакалаврын сургалт эрхэлдэг. “Нүүр ам судлал” хөтөлбөөр 2002 онд анхны элсэлтээ авч 2007 он анхны төгсөлтөөр 9 төгсөгч төгссөн байна.

“Нүүр ам судлал” хөтөлбөрийг НАС-ын сургууль, Нүүр ам судлалын эмнэл зүйн тэнхим (эмнэлзүйн тэнхимд нүүр амны эмчилгээ, нүүр амны согог засал, нүүр амны мэс засал, нүүр амны гажиг заслын хичээлүүд ордог), Хүүхдийн нүүр амны өвчин судлалын тэнхимүүд хэрэгжүүлж байна.

2021 оны байдлаар нийт 15 удаагийн төгсөлтөөр 587 (17%) НАС-ын эмч бэлтгэснээс дунджаар 96,3% мэргэжлээрээ ажиллаж байна. Нүүр ам судлалын бакалаврын хөтөлбөрт нийт 5 дамжаанд 372 (24%) оюутан суралцаж байна.

НАС-ын хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт 19 доктор (ШУ-ны 4, АУ-ны 15) багш, 26 магистр багш хичээл зааж байна. 12 нүүр амны их эмч, 25 АУ-ны эмч, боловсрол судлалын 9 багш НАС-ын хөтөлбөрт хичээл заан ажиллаж байна.

Хичээлийн 4 байртай, НАС-ын сургууль нь хичээлийн II байранд сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа. Сургуулийн хэмжээнд нэг ээлжинд 600 гаруй оюутны суудалтай, НАС-ын сургуулийн байранд дуураймал орчин бүрдүүлсэн эмнэлзүйн хичээлийн танхимуудтай

“Ач” АУИС-д батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт 36 эрх зүйн дүрэм журмуудтай. Үүнээс оюутанд чиглэсэн – 14 дүрэм журам байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- “Ач” АУИС-ийн хөтөлбөрийн дэд хороо нь хөтөлбөрийн ерөнхий хороогоор төлөвлөгөөний өөрчлөлтийг оруулж батлуулсан. Суралцагчийн мэргэжлийн ур чадварыг хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдуулан өөрчлөн шинэчилсэн.
- 2009, 2012 онуудын сургалтын төлөвлөгөөний кредит цагийн хувиарлалт, 2014 оны сургалтын төлөвлөгөөний кредит цагийн хуваарилалтууд өөрчлөгдсөн байна. Сургалтын төлөвлөлт нь ерөнхий суурь 24 кредит цаг, мэргэжлийн суурь хичээлийн 38 кредит цаг, мэргэжлийн хичээлийн 98 кредит цаг нийт 160 кредитийн хичээлүүдийг үзэхээр өөрчлөгдөн одоо мөрдөгдөж байна.
- Монголын нийгмийн эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж иржээ.
- “Ач” АУИС-ийн “Нүүр ам судлал” бакалаврын хөтөлбөрийн зорилго нь: “Хүн амын дундах амны хөндийн өвчлөлийг бууруулах, эрүүлжүүлэх, өвчин эмгэгээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, зонхилон тохиолддог өвчнийг оношлох, эмчлэх арга барилыг зохих түвшинд эзэмшсэн, эмчийн ёс зүй, төрийн хуулийг чандлан сахидаг, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн хүрээнд ажиллах чадвартай нүүр амны их эмч бэлтгэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.
- “Ач” АУИС нь НА-ны их эмчийн ажлын байрны тодорхойлолтод нийцсэн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор өөр хоорондоо нягт уялдаа холбоо бүхий дээд боловсролын ерөнхий суурь 15 хичээл, мэргэжлийн суурь 19 хичээл, мэргэшүүлэх чиглэлийн 46 хичээлийг багтаасан сургалтын хөтөлбөрийг холбогдох мэргэжлийн тэнхимүүд болон сургалтын бааз эмнэлэгүүдийг түшиглэн явуулдаг байна.
- Нүүр ам судлалын бакалаврын хөтөлбөрийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад, дотоодын хөтөлбөрүүдийг харьцуулсан судалгааг хийж өөрийн хөтөлбөрөө үнэлжээ.
- НА-ны их эмч бэлтгэх сургалтын төлөвлөгөө нь оюутны суралцах хугацаа, багц цагийн хувьд гадаадын зарим орнуудын шүдний их сургуулиудын хөтөлбөртэй ойролцоо, олон улсын түвшинд дүйж очсон гэж үзэхээр байна.

Ач АУИС-ийн НАС-ын сургалтын хөтөлбөрийг Гадаадын ижил төстэй сургуулиудын хөтөлбөртэй харьцуулсан байдал:

№	Үзүүлэлт	Ач АУИС-ийн НАСС	Ионсейн и сургууль	ОХУ-ын Шүдний Их Сургууль
1	Хөтөлбөрийн агуулгын	160 кр	76+ 165 кр	211 кр

	багтаамж			
2	Судлах хичээлийн тоо	80	33+70	51
3	Суралцах хугацаа	5 жил	2+4 жил	5 жил
4	Суурь хичээлийн агуулгын багтаамж	24	76	53
5	Мэргэжлийн суурь хичээлийн агуулгын багтаамж	38	42	75
6	Мэргэшүүлэх хичээлийн агуулгын багтаамж	98	123	83
7	Бэлтгэж байгаа мэргэжилтэн	Нүүр амны их эмч	шүдний их эмч	шүдний их эмч

Ач АУИС-ийн НАС-ын сургалтын хөтөлбөрийг дотоодын их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулсан байдал:

№	Үзүүлэлт	Ач АУИС-ийн НАСС	АШУУИС НАСС	Этүгэн ИС НАСС	МУИС НАСС
1	Хөтөлбөрийн агуулгын багтаамж	160 кр	201	185 кр	199 кр
2	Судлах хичээлийн тоо	80	126	80	80
3	Суралцах хугацаа	5 жил	6 жил	5 жил	5 жил
4	Суурь хичээлийн агуулгын багтаамж	24	56	44	24
5	Мэргэжлийн суурь хичээлийн агуулгын багтаамж	38	44	69	38
6	Мэргэшүүлэх хичээлийн агуулгын багтаамж	98	101	72	98
7	Бэлтгэж байгаа мэргэжилтэн	Нүүр амны их эмч	Шүдний их эмч	Шүдний их эмч	Шүдний их эмч

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд МШМХ, бусад хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, Нүүр амны их эмчийн ажлын байрны тодорхойлолтод нийцсэн мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэх шаардлагыг хангах зорилгоор 89 эмнэлэгийн ажил олгогчдоос төгсөгчдийн талаарх санал асуулга 2 жил тутамд авч эмнэл зүйн дадлагын ур чадварыг нэмэгдүүлэх, эмч, эмнэлэгийн ажилтан, үйлчлүүлэгчийн харьцаа, хандлагыг сайжруулах, бие даан болон багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ач АУИС -ийн НА-ны их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрөө Эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээ, Боловсролын төрийн захиргааны төв байгууллагын бодлогод нийцүүлэн “Дээд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого”, “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал”, “Тогтвортой хөгжлийн бодлого”, “Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр”-ийн хөгжил зэрэгт нийцүүлэн Анагаахын боловсролын хөгжлийн дэлхийн нийтийн чиг хандлагад ойртуулах зорилт тавин ажиллаж Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хөгжүүлэх чиглэлд ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Монгол улсын нийгэм, эдийн засаг, технологи, шүдний салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийхдээ иж бүрэн хандаж байх.
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулахдаа сургалтын хөтөлбөрийн цогц шинжилгээ хийж хэвших.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- НАС-ын бакалаврын сургалтын хөтөлбөр нь орчин үеийн анагаах ухааны нотолгоонд суурилсан, нэгдмэл сургалтын үзэл баримтлалтай.
- Ач АУИС-ийн НАСС нь “Дэлхий дахинд давшингуй хөгжиж буй НАС-ын салбарын хөгжил, олон улсын стандартад нийцүүлэн хөрвөх чадвартай, эзэмшсэн мэргэжлээрээ эрүүл мэндийн салбарт ажиллах боломж нь нээлттэй эмч мэргэжилтэн бэлтгэх нь НАСС-ийн эрхэм зорилгын нэг гэж тодорхойлсон байна.
- НАС-ын бакалаврын хөтөлбөрийн зорилго нь(PEO): НАС-ын ШУ-ны сургалтын хөтөлбөрөөр нүүр амны түгээмэл тохиолдох өвчин эмгэгүүд, согог, гажигуудын оношилгоо, эмчилгээ ба урьдчилан сэргийлэх анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх чадвар бэлтгэлтэй, эмнэл зүйн харилцааны болон гардан хийх ур чадвартай, эмчийн ёс суртахуунаар төлөвшсөн, зөв хандлагатай нүүр амны их эмч мэргэжилтэнг бэлтгэхэд оршино гэжээ.
- Тухайн сургалтын хөтөлбөр нь тогтсон үнэлгээний системтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн бодлого шийдвэр болон хөтөлбөрийн зорилго, зорилт бусад мэдээллийг хүргэх Cloud University нэгдсэн системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Ач АУИС-ийн алсын харааг тодорхойлон түүнийг хэрэгжүүлэх хүрээнд хийх ажлуудыг дэс дараалан төлөвлөн гаргахад анхаарах.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалыг мөрдлөг болгон тус сургалтын хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулж мөрдөн ажиллаж байна. Манай улсын эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээнд аль болохоор нийцэхүйц сургалтын технологийн шинэчлэл хийхээр гадаад, дотоодын НАС-ын сургуулийн хөтөлбөрүүдийг судлан харьцуулан хөтөлбөртөө боловсруулалт хийсэн байна.
- Дэлхий дахины анагаах ухааны боловсрол судлалд гарч байгаа шинэлэг үзэл санаа, шинэ үзэл баримтлалуудаас судалж, нэвтрүүлэхээр мэргэжлийн online сургалтуудад багш нар хамрагдан суралцдаг байна.
- Сонгон шалгаруулалтаар орж ирсэн багш нарыг Багш хөгжлийн албанаас зохион байгуулж буй Багшийн ур чадвар дээшлүүлэх 6 модулын сургалтанд хамруулж багшлах эрх олгодог, 2017-2018 онд АШУҮИС-тай хамтарсан багш хөгжүүлэх хамтарсан сургалтыг зохион байгуулжээ, мөн багш нарыг сурганы болон анагаахын боловсрол судлалын сургалтад тогтмол хамруулдаг байна.
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, стандартад явцын болон тогтмол үнэлгээг хийж, сургалтын хөтөлбөрийн агуулга нь төгсөөд ажиллах ажлын байрны болон үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа эсэхийг тогтоодог байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн хөтөлбөр нь “Нүүр ам судлал” бакалаврын сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал харьцангуй жигд байгаа нь хичээлийн хөтөлбөр, үнэлгээний хэрэглэгдэхүүнтэй танилцахад ажиглагдаж байлаа.

Анхаарах асуудал:

- Багш нарыг гадаадын болон дотоодын их дээд сургуулийн багш нарыг хамруулсан сургалтанд оролцуулах талд илүүтэй анхаарах.
- Багшийг өөрийгөө хөгжүүлэх талд урамшуулан дэмжиж, ажиллах тал дээр анхаарах.
- Багшийн хөгжлийн асуудлыг чухалчлан анхаарч багш нарыг өөрөө суралцах болон окутан, резидент, магситрантуудыг сургах дэвшилтэт аргууд, үнэлгээний аргуудыг зөв сонгож ашигладаг, сургалтанд судалгаа шинжилгээний аргуудыг хэрэглэх талаар эрэл хайгуул хийдэг, чадварлаг мэргэжилтнүүд болгоход анхаарч урамшуулан ажиллах.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй харилцан уялдаатай, сонгох боломжтой тасралтгүй хөгждөг байна. 2014 онд сургалтын төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтөөр ерөнхий суурь хичээлээс Мэдээллийн технологи, мэдээллийн систем 2 кр, биофизик 2 кр хасагдаж Англи хэл, Анагаахын хими хичээлүүдийн багц цаг хасагдсан бол Монгол хэл бичиг найруулга зүй 3 Сэтгэлгээний түүх соёл 3 кр, Монголын түүх соёл, ёс заншил хичээлийн багц 3 кр болж нэмэгдсэн байна.
- Мэргэшүүлэх хичээлээс Хүүхдийн нүүр амны мэс засал-2, Нүүр амны гажиг засал - 2, Анагаах ухааны ёс зүй ба дентологи хичээлүүд хасагдсан бол Шүдний сувгийн эмчилгээ I хичээлийн нэр Зөөлцийн үрэвсэл болж, Шүдний сувгийн эмчилгээ II нь Сурвалжийн оройн эдийн үрэвсэл болж өөрчлөгдсөн байна.

Хөтөлбөрийн багц цагийг агуулгаар харьцуулан үзвэл:

№	Багц цагийн агуулга	Багц цаг (2009)	Нийт багц цаг эзлэх хувь	Багц цаг (2014)	Нийт багц цаг эзлэх хувь	Хөтөлбөрт тав гдах харьцаа
1	Ерөнхий суурь	27,5	15,5	24	15	30% хүртэл
2	Мэргэжлийн суурь	43,8	24,7	38	23	25 хувиас ихгүй
3	Мэргэшүүлэх	105,8	59,8	98	62	45 хувиас доошгүй
	Нийт	177	100	160	10	17 багц цагаар буурсан

Нүүр ам судлалын хөтөлбөрийн хичээлүүдийн уялдаа

Дамжаа	Хичээлүүд	Эзэмших мэдлэг
I-II дамжаа	Ерөнхий болон мэргэжлийн суурь хичээлүүдийн мэдлэг олгох	Онолын мэдлэг
III-IV дамжаа	Нүүр амны их эмчийн эзэмшсэн байх ур чадваруудыг олгох	Онолын мэдлэг Гардан үйлдэл Ур чадвар
V дамжаа	Нүүр амны их эмчийн ур чадвар, харилцаа хандлагыг төлөвшүүлэн дадлагажуулж цогц чадамж өгөх	Онолын мэдлэг Гардан үйлдэл Оношилгоо

		Эмчилгээ Эмнэл зүйн ур чадвар
--	--	----------------------------------

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Сургалтыг багш төвтэй удирдан чиглүүлж бодит байдлыг дүгнэх, хичээл нь онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, оюутны идэвхийг дээшлүүлж бие даах чадварыг сайжруулахад чиглэсэн оюутны цогц чадамжид суурилсан нь онцгой ач холбогдолтой байна.

Анхаарах асуудал:

- Хичээл тавигдсан хуваарийн дагуу ордог тул багш сонгох боломж хязгаарлагдмал байдаг. Энэ талаар эрэл хайгуул хийн ялангуяа мэргэшүүлэх хичээл заадаг багш нарыг сонгох боломжоор хангах

Зөвлөмж:

- Мэргэшүүлэх хичээл заадаг багш нарыг оюутан өөрсдөө сонгох боломжоор ханган олон оюутан сонгосон багшийг урамшуулан дэмжих

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн хөтөлбөр нь сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүй болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан.
- Жижиг бүлэгт суурилсан сургалт, асуудалд суурилсан сургалт, багш төвтэй сургалт, эмнэл зүйн тохиолдолд суурилсан сургалт, интерактив сургалтын арга зүйгээр хичээлээ явуулдаг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ач АУИС-ийн НАСС-ийн сургалтын онцлог нь жижиг бүлгээр, эмнэл зүйн тохиолдлоор болон орны дэргэд өвчтөн үзэх, интерактив, репродуктив, эврестик хэлбэрүүдээр явуулж байна.
- Уламжлалт сургалтын зэрэгцээ мэдээллийн системийг хөгжүүлэхэд анхаарч нотолгоонд суурилсан хэлбэрээр сургалтыг зохион байгуулж байна. (ярилцлага, ажилбарын норм, өвчний түүх бичих, гардан ажилбарын шалгалт, хичээл бүрээр асуулт, хариулт, бүлэг бүрд аман шалгалт)
- Хичээлийн хэлбэр: Лекц- үзүүлэн таниулах, өгүүлэн заах
Клиник лабораторийн, үйлдвэрлэлийн дадлага- загвар дээр ажиллах
Семинар- мэдлэгийг гүнзгийрүүлэх ач холбогдолтой.

Анхаарах асуудал:

- Оюутан төвтэй сургалтыг явуулах: энэ нь оюутан өөрөө сэтгэн бодох, бодит байдалд үнэлэлт өгөх цаашид хийх эмчилгээний төлөвлөгөөг зөв боловсруулан гаргах, бие даан үнэлэлт дүгнэлт өгөх чадвар нь дээшилнэ. Сургалтад багш голлон

удирдан чиглүүлэх, бодит байдлыг дүгнэх байдлаар оролцох нь тухайн оюутны идэвхийг дээшлүүлж бие даах чадварыг сайжруулахад онцгой ач холбогдолтой байдаг.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Шалгалтыг үнэлэх арга хэлбэрүүд:

Мэдлэг үнэлэх шалгалт	Ур чадвар, хандлага үнэлэх шалгалт	Цогц чадамж Үнэлэх шалгалт
Аман шалгалт 100% Мэргэшүүлэх хичээл 71,8%	Эмнэл зүйн дууриамал орчин дахь шалгалт/OSCE, OSPE/	Эмнэл зүйн дууриамал орчин дахь шалгалт/OSCE, OSPE/
Бичгийн шалгалт/Эссе/ Мэргэшүүлэх 12,5%	Өртөөчилсөн шалгалт	Эмнэл зүйн дасгал үнэлгээ //Mini -Clinical examination/
Олон хувилбарт сорил /MCQ/ мэргэшүүлэх 59,3%	Урт богино эмнэл зүйн тохиолдол шийдвэрлэх	Гардан гүйцэтгэлийг ажиглах үнэлгээ/DOP/
Эмнэл зүйн тохиолдолд суурилсан сорил 28,1%	Гардан үйлдлийн шалгалт 21,8%	Портфель үнэлгээ
Компьютерт суурилсан сорил	Өвчтөний менежмент/Өвчний түүх бичих/	360 хэмийн үнэлгээ /Зөвхөн харилцаа хандлага үнэлнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сорилын шалгалт
- Аман шалгалт
- Гардан шалгалт

Анхаарах асуудал:

- Одоогоор тус сургуульд Хүүхдийн нүүр ам судлалын тэнхим, Эмнэл зүйн тэнхим гэсэн 2 тэнхимтэй боловч нүүр амны эмчилгээ, нүүр амны согог засал, нүүр амны гажиг засал, нүүр амны мэс заслын гэх мэтчилэн хичээлүүд ордог. Цаашид сургуулийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд эдгээр салбаруудыг үе шаттайгаар бие даан тэнхим болгон хөгжүүлэхэд бэлтгэх боловсон хүчин, шинэ техник, тоног төхөөрөмжөөр ханган ажиллах талд анхаарч ажиллавал тэнхимүүд өөрсдийн ирээдүйн тэнхимийг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөгөө гарган ажиллах боломж нь бүрдэх талтай.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Ач” АУИС-ийн НАСС-ийн оюутнуудын сурах орчин, сургалт судалгаа явуулах анги, танхим лаборатори, техник тоног төхөөрөмж нь суралцах, болон багшлах нөхцлийг бүрдүүлсэн бакалаврын боловсрол эзэмшигч Нүүр ам судлаач эмчийг бэлтгэн төрүүлэхэд хангалттай сургалтын орчин гэж үзэж байна. Мөн нарийн мэргэжлийн үзлэгийн кабинет болон шүд урлах лабораторийн өрөөнүүдийн тоног төхөөрөмж муляж, симуляторийн тоо 2015 оноос одоог хүртэл нэмэгдсэж тохижсон байдал, оюутнууд суралцах давтамжийн тоо болон хүртээмжтэй байдал нь нотлох баримтуудаар нотлогдлоо.
- 2017-2019 онд сургуулийн гадаад орчныг сайжруулж эргэн тойрны талбайг цементлэж урсгал засваруудыг хийгсээр ирсэн байна. Үр дүнд нь сургуулийн гадаад дотоод орчин өөрчлөгдөн сайжирч тоосжилт багасан өөрчлөгдсөнийг нотлох баримтуудаар хангалттай гэж дүгнэж байна. Оюутны дотуур байранд урсгал засвар хийгдсэн байна. Дотуур байранд угаалгын өрөөг ажиллуулдаг нь цэвэр тохитой орчинг бүрдүүлсэн байна. Оюутнуудын асуумжаас үзэхэд сургуулийн болон сургалтын орчин нэмэгдэн сайжирч байдаг гэсэн нь суралцах явцдаа сэтгэл ханамжтай байдал харагдаж байна.
- Оюутны дотуур байранд эрүүл мэндийн төв, нийтийн номын сан байрладаг нь сайшаалтай тал байна.
- Ач АУИСургууль нь нийт багш, ажилтан, оюутны ажиллаж суралцах орчныг боловсролын байгууллагад тавигдах стандартын дагуу нийцүүлэн эрүүл, аюулгүй, тохилог орчин бүрдүүлэх зорилготойгоор анхааран ажилладаг хамт олон байна. Мөн нарийн мэргэжлийн сургалт явуулдаг олон улсын сургуулиудын жишгээр тус сургууль нь өөрийн бааз эмнэлэгтэй болж байгаа нь хамт олны том амжилт юм. Эмнэлэгтэй болж байгаагаараа эмнэл зүйн сургалтуудыг явуулж оюутны дадлагажих орчин бүрдэх давуу тал харагдаж байна. Суралцах орчин нөхцлийн талаар авсан оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаагаар дундаж үнэлгээ 61.7% - тай байна. НАСС-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл нь Дээд боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага, стандартыг хангасан гэж дүгнэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Ач” АУИС нь өөрийн сургалтын эмнэл зүйн бааз эмнэлгийн барилгыг шинээр ашиглалтанд оруулахад бэлэн болжээ.
- Тус сургуулийн нарийн мэргэжлийн эмч багш нар оюутнуудын хамт үзлэг хийж зөвлөгөө өгөх болсноор оюутнуудын эмнэл зүйн гардан үйлдлийн ур чадвар намэгдэх нь давуу тал байна.
- 5-р дамжааны оюутнууд нь шинээр элссэн оюутнууддаа амны хөндийн үзлэгийг хийдэг
- Суралцагч оюутнуудыг СХД-ийн ЭМТөвтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг

Анхаарах асуудал:

- Одоогор ажиллаж байгаа зарим эмнэл зүйн сургалтын үзлэгийн өрөө болон оюутны дотуур байрны агааржуулалтын системийг сайжруулах

Зөвлөмж:

- Оюутнуудад амны хөндийн үзлэг хийсэн үр дүнгээ судалгааны ажил болгох

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутан болон багшид зориулагдсан сургалтын хэрэглэгдэхүүн болох суурин компьютер, принтер, бичгийн цаас, самбарын үзэг, оюутанд хэрэглэгддэг хиймэл ам, гардан үйлдэлд хэрэглэгддэг шүднүүдийг сургуулиас хангалттай хэмжээгээр хангадаг байна. Суралцагч оюутнууд нь эхлээд эмнэл зүйн хиймэл орчинд гардан үйлдлийн дадлагыг симулятор дээр хийж дадсаны дараа эмнэл зүйн сургалтын өрөөнүүд болох нүүрний мэс засал, нүүр амны эмчилгээ, хүүхдийн нүүр амны эмчилгээ, нүүр амны согог заслын чиглэлээр ажилладаг. Үзлэгийн өрөөнүүдэд багш нарын хамт үйлчлүүлэгчийг үзэж зөвлөгөө өгдөг байна. Эдгээр өрөөнүүдээс гадна ариутгалын болон хиймэл шүдний лабораторийн өрөөнүүдэд хамтран үйл ажиллагаагаа явуулдаг нь нотлогдлоо.
- Шинэ эмнэлгийн барилга ашиглалтанд орсноор НАССургууль нь эмнэл зүйн дадлага хийх иж бүрэн тоноглогдсон 13 үзлэгийн сандалтай болж эмнэл зүйн өмнөх дадлагын сургалтыг 8 симулятор авагддаг болон авагддаггүй шүдэлбэр хийх нэг, нэг лаборатори, 5 эмнэл зүйн дадлагын өрөө, эмнэл зүйн өмнөх дадлагын өрөө 2, хичээлийн 5 танхим 10 гаруй бааз эмнэлгийн 30 гаруй өрөөнүүдэд хөтөлбөр хэрэгжүүлэх сургалт явуулж байгаа нь сургалтын чанарыг сайжруулах нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж байна. Мөн “Ач дентал клиник” шүдний эмнэлгийг байгуулан ажиллуулж байгаа нь сургалтыг эмнэл зүйд ойртуулсан давуу тал харагдаж байна.
- Ач АУИС нь “Нээлттэй их сургууль” байх стратеги зорилтын хүрээнд Cloud University системийг ашигладаг нь СБЗА, багш, суралцагчид, эцэг эхчүүдийн хоорондын харилцааг сайжруулахаас гадна ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор ашиглаж байгаа нь сайшаалтай байна.
- Лекцийн заалуудыг орчин үеийн мэдээллийн технологийн дэвшилтэт техникүүдээр тоногдосон нь лекцийг анагаах ухааны боловсролын дэвшилтэт аргуудаар хөтлөн явуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нүүр амны мэс засал, нүүр амны эмчилгээ, нүүр амны согог заслын 3 мэргэжлийн чиглэлээр эмнэл зүйн сургалт явуулах өрөөнүүдтэй.
- Шинэ эмнэлэгийн үзлэгийн болон сургалтын өрөөнүүд нь олон улсын эмнэл зүйн сургалтын түвшинд дүйцэхүйц болсон

Анхаарах асуудал:

- Одоогийн ажиллаж байгаа үзлэгийн өрөөнүүдийн багажны ариутгалын асуудалд анхаарах

Зөвлөмж:

- Үйлчлүүлэгчдийн үзлэгийн картыг бүрдүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн номын санд нийт 17626 ширхэг ном сурах бичиг, эрдмийн бүтээл, тогтмол хэвлэл бүхий сан хөмрөгтэй . 1584 гаруй уншигч хэрэглэгчдэд мэргэжлийн 3 номын санч ажилладаг байна. Үүнээс НАСудлалын хөтөлбөрийн ном 1392 ширхэг байна. Lib4U программыг ашиглан электрон номын сан болон электрон каталог байгуулан интернетээр уншигчдад ашиглуулдаг байна.
- Номын сан нь Д.Нацагдоржийн нэрэмжит салбар номын сан болон ЭЗШУИС-ийн номын сангуудтай ном солилцдог гэрээтэй ажилладаг, үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн сантай болох зорилгоор МҮНСантай хамтран ажиллаж ZOTERO программд “Монголын Анагаах Ухаан”, “Нүүр ам судлал”, “Нүд судлал” сэтгүүлүүдийн бүх өгүүллийг оруулж уншигчдад лавлагаа өгөн ашиглуулж байгаа нь уншигчдад хүртээмжтэй сайн туршлага болжээ.
- Нүүр ам судлалын сургууль нь нийт 379 оюутантай, нэг ангид суралцах оюутны тоо 12-15 байдаг тул мэргэжлийн ном сурах бичгийн хүрэлцээ хангалттай юм байна.
- Мөн Google education үүлэн технологид суурилсан цахим сургалтын системийн хэрэглээ, хүрэлцээ боломжийн гэж үзэж байна. Бид номын сангийн ном, сэтгүүл, багш нарын судалгааны ажлууд, төгсөх оюутнуудын судалгааны ажлуудын эмхэтгэлүүдийг үзэж танилцан нотоллоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон сайхан эрдмийн болон инновацийн бүтээлүүдтэй
- Инновацад түрүүлсэн бүтээлтэй

Анхаарах асуудал:

- Google education үүлэн технологид суурилсан цахим сургалтын системийн хэрэглээг, цаашид илүү хүртээмжтэй байх талаар анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

Зөвлөмж:

- Цаашдаа номын сангийн үйлчилгээг олон улсын номын сангийн үйлчилгээний шаардлагад нийцсэн болговол сайн байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн ерөнхий хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо, мэргэжлийн хөтөлбөрийн багуудын ажил үүргийн хуваарь, зарчим болон хурлуудын

шийдвэрүүд нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангахад чиглэгдсэн байна.

- Их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөны эрхзүйн баримт бичгүүдэд тулгуурлан сургалтын төлөвлөгөөг боловсруулсан.
- Тухайн хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлт байхгүй харин шилжилт хөдөлгөөний өргөдөл гомдлыг шалтгаанаар нь шинжилж ажилладаг ажээ.
- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, үйлчилгээний орц-явц-гарцад PDCA шинжилгээ хийсэн нь урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэл, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээний механизм бүрдсэн байна.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн анализыг шинжлэхэд сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахын төлөө дотоод нөөц, боломжийг оновчтой хуваарилж; профессор багш, ажилтан, ажилчдын хөдөлмөрлөх, суралцагчдын суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлдэг юм байна гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрх зүйн орчин бүрдсэн, холбогдох дүрэм, журмуудыг мөрдөн ажиллаж байна.
- Дүрэм журмын шинэчлэл, сайжруулалтыг тодорхой үе шаттайгаар тогтмол хийж ирсэн.
- CLOUD UNIVERSITY системийг нэвтрүүлснээр сургалтын бүх үйл ажиллагааг шуурхай явуулах, ил тод байдлыг хангах, хяналт тавих нөхцөл бүрдсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө болон тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд нарийвчилсан дүн шинжилгээ хийж ажиллах
- CLOUD UNIVERSITY системийн зарим дутагдалтай талуудыг анхаарч, сайжруулах

Зөвлөмж:

- Эрүүл мэндийн салбарын хурдацтай өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлж сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход анхаарч ажиллах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлангууд, багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам, багш, суралцагчдын зүгээс нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт, төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт

материал бүхий илрэл нотолгоонуудыг шинжихэд дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоох, багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгааны ажлууд нь онцгой нөхцөл байдлын өнөө үед хэмнэл нь алдагдсан тул хуучин голдрилд оруулахад анхаарч ажиллах хэрэгтэй болох нь ажиглагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс нийгэмд тодорхой үйлчилгээ үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- Гадаад хамтын ажиллагааны гэрээ, гэрээний хугацаа, хамтын үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээний тайлан дутагдалтай байсан.
- Багш, оюутан солилцооны хөтөлбөр идэвхитэй хэрэгждэггүй.
- Төгсөгчидтэй эргэх холбоо, төгсөгчдийг АЧ АУИС дээрээ давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл хангалттай байсангүй.

Шаардлага:

- Гадаад хамтын ажиллагааны гэрээ, гэрээний хугацаа, хамтын үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээний тайлан, тайлангийн мөрөөр хийсэн ажлуудаа тодорхой болгох
- Оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
- Төгсөгчдөө Ач АУИС дээрээ давтан сургалтад хамруулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Ач АУИС-ийн НАС-ын ангид 2016 онд 265, 2017 онд 237, 2018 онд 240, 2019 онд 265, 2020 онд 315 оюутан суралцаж байгаа судалгаанаас харахад суралцагчдын тоо харьцангуй тогтвортой, сүүлийн 4 жилд өсөлттэй байгаа үр дүн ажиглагдсан. Тэр хэрээр Сургалтын төлбөрөөс тухайн хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүн өссөн байна.
- Үүсгэн байгуулагчын хөрөнгө ба сургалтын төлбөрөөс санхүүжиж ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулж буй тухайн хөтөлбөрийн сүүлийн 5 жилийн санхүүгийн тайланг шинжлэхэд орлого нь урсгал зардал, сургалтын зардал, тоног төхөөрөмжид эргүүлэн зарцуулагддаг байна. (2016 онд 7951.3, 2017 онд 8082.6, 2018 онд 8744.1, 2019 онд 8908, 2020 онд 8733.2 сая₮)
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн орлого, зарцуулалтын тайлан, үндсэн хөрөнгийн бодит хэмжээг жил жилээр гаргасан нотолгоог шинжилэхэд санхүүжилтийг тогтворжуулахын тулд хөрөнгө оруулалтын шинэ арга барил нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж санхүүгийн хувьд тодорхой хэмжээний эрх мэдэлтэй.
- Элсэгчдийн тоо өссөн үзүүлэлттэй

Анхаарах асуудал:

- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоонд дүн шинжилгээ хийж ажиллах
- Хувийн хэвшлийн санхүүгийн дэмжлэг авч ажиллах дээр анхаарах
- Тухайн хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн хөтөлбөрийн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтыг тодорхой болгох

Зөвлөмж:

- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоонд дүн шинжилгээ хийх, түүний мөрөөр төсөв төлөвлөх
- Тухайн хөтөлбөр хөгжүүлэлтэд зориулсан төсвийг тодорхой болгох

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлтүүдийн маш сайн гэсэн хариулт авсан хувь нь тухайн мэргэжлийн эрэлт хэрэгцээ-96%, бие даан ажиллах ур чадвар-69%, мэргэжлийн түвшин-66%, манлайлал-61%, бичиж тайлагнах-46%, ерөнхий суурь мэдлэг-6%, багаар ажиллах чадвар-0% гэх мэт байна. Иймд суралцагчдын манлайлал, бичиж тайлагнах, ерөнхий суурь мэдлэг, багаар ажиллах чадварт анхаарч ажиллах хэрэгтэйг харуулж байна.
- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал, хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримтуудыг шинжилвээс суралцагчдын эрэлт хэрэгцээг үнэхээр хангаж чадаж буй эсэх нь тодорхой биш байна. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтээ тогтвортой байдлаа хангахуйц байхаар ажлаа төлөвлөх хэрэгтэйг харуулж байна.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтын судалгаанд нийт төгсөгчдийн 1,5% нь ахлах зэрэгтэй, доктор-1, магистр-15 байна.
- 2016-2018 онд хэрэгжүүлсэн “Зүрхний титэмт судсанд стент тавьсаны дараах үеийн цусан дахь бүлэгнэлтийн маркер болон цитоконы судалгаа”, “Хүүхдийн зүрхний зонхилон тохиолдох хавсарсан гажгийн мэс засал эмчилгээний технологийг болосвронгуй болгох нь”, “Липидийн солилцооны эмгэгүүдийн эфферент эмчилгээ” төсөл хөтөлбөрүүд нь тухайн НАС хөтөлбөртэй хамааралгүй гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2007 оноос хойшхи төгсөгчдөө тандан судлах судалгаа хийсэн
- Аймгуудын ЭМГ болон боловсролын газруудтай хамтран ажилладаг

Анхаарах асуудал:

- Зорилтот бүлэгт хандсан идэвхжүүлэлтийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт, Ач АУИС-ийн www.ach.edu.mn вэб сайт, Ач АУИС-ийн албад, тэнхмүүдийн төлөвлөгөө, тайлангуудыг шинжлэхэд Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.
- Ач АУИС-ийн профессор багш нарын боловсруулсан хөтөлбөрүүд, сурах бичгүүд, сургалтын гарын авлагууд нь тухайн сургуулийн тухайн хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгддэг. Гэхдээ багш нарын бүтээл болон хөтөлбөрийн агуулгыг веб сайтад байршуулах, эргэх холбоог улам боловсронгуй болгох хэрэгтэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг тогтмол шинэчлэгддэг, нийтэд ил тод байрладаг
- CLOUD UNIVERSITY мэдээллийн системийг сургалтад ашигладаг.
- Сургууль, салбар сургууль, хөтөлбөрийн хороо, мэргэжлийн тэнхмүүд мэдээлэл хүргэх сувгуудтай, мэдээлэл нээлттэй байршдаг.

Анхаарах асуудал:

- Веб хуудсыг системтэйгээр баяжуулах
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг арга хэлбэрийг боловсронгуй болгох

Зөвлөмж:

- Электрон мэдээллийн хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох, орчин үеийн техник хангамжийг өргөжүүлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Ач АУИС нь Монгол улсын боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам”, “Босго оноо тогтоох” тушаалыг тус тус үндэслэл болгон оюутан элсүүлэх үйл ажиллагааг захирлын тушаалаар баталсан элсэлтийн комиссын бүрэлдэхүүнтэй ил тод нээлттэй явуулдагийг тухай тайланд дурьдагдсан нь жил бүрийн оюутан элсүүлэх тоо, сургуулийн ректорын тушаалууд, элсэлтийн комиссын шалгаруулалтын баримтууд зэргээс үндэслэн нотлох баримтуудаар нотоллоо.
- Шинээр элсэгчдийн тоог тухайн жилийн төгсөгчдийн тоо, эрүүл мэндийн салбарт ажлын байрны эрэлт хэрэгцээ, сургуулийн дотоод болон гадаад хүчин чадалд үндэслэн жил бүр сургуулийн удирдах зөвлөлийн хурлаар тогтоож мөрддөг байна.

- Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлээс гадна урлаг, спортоор амжилт гаргасан, хими, биологийн олимпиад, улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд эхний байранд орж амжилт байгуулсан элсэгчдийг өөрсдийнх нь хүсэлтээр сонгосон мэргэжлээр нь сургалтын төлбөрөөс хөнгөлж сургадаг нь оюутнуудын төлөөллүүдийн уулзалт ярилцлагаар нотлогдлоо.
- Диплом болон бакалаврын зэрэгтэй элсэгчдийн тоо жилээс жилд нэмэгдсэн үзүүлэлт ихсэж байгаа нь сургалтын хөтөлбөрийн дүйцүүлэх хичээлийн кредит онооны батлагдсан журамтай танилцаж шаардлага хангахуйц гэж дүгнэлээ.
- НАССургуульд элсэгчдийн тоо бусад мэргэжлийн элсэгчдийн дундаж онооноос өндөр байдаг нь энэ мэргэжлийг сонгогчдын тоо ихэссэн болон олон эрдэмтэн доктор, профессорууд байдагт, сургалтанд зориулсан материаллаг бааз хангалттай зэргээс шалтгаалж бусад мэргэжлийн элсэгчдийн дундаж онооноос нүүр ам судлалын сургуулийн элсэгчдийн дундаж оноо өндөр байдаг болов уу гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шинээр элсэгчдийн чиглүүлэх сургалтыг тогтмол явуулдаг
- Нээлттэй хаалганы өдөрлөг тогтмол зохион байгуулдаг

Анхаарах асуудал:

- Хөдөлмөр эрхэлж байгаа оюутнуудын сурлагад СБЗА анхаарч ажиллах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутанд чиглэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөө нь шинэ элсэгч оюутан, суралцагч оюутан, төгсөгч оюутан гэсэн ангиллаар явагддаг нь сайшаалтай байна. Эдгээр төлөвлөгөөт үйл ажиллагануудын хөтөлбөр, хувийн шүдний эмнэлгүүдтэй танилцуулан хөдөлмөр эрхлүүлэх үйл ажиллагаа, зорилтот бүлгийн оюутанд онцгойлон дэмжлэг үзүүлдэг нь оюутнуудтай хийсэн уулзалт ярианаас нотлогдлоо.
- 2020- 2021 оны хичээлийн жилд оюутны google form ашиглан цахим хэлбэрээр авсан сэтгэл ханамжийн судалгаанд Нүүр ам судлалын 79 оюутан хамрагдсан байснаас мэргэжлийн чиглэлийн уралдаан тэмцээн, олон нийтэд чиглэсэн арга хэмжээ, спорт урлагийн арга хэмжээ явуулдаг нь ажил дээр гарсны дараа их үр дүнтэй байдаг гэж төгсөгчдийн уулзалтын төлөөллүүд онцлон нотоллоо.
- Оюутанд чиглэсэн эрүүл мэндийн 2-р шатлалын үйлчилгээг УБТЗамын эмнэлэг, СХД-ийн эрүүл мэндийн төвүүд, 1-р шатлалын тусламж үйлчилгээг СХД-ийн “Гурван жаргал хайрхан” Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллаж оюутнуудыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулдаг. 2015 оноос сургуулийн нийт оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж ажилладаг нь оюутнуудынхаа эрүүл мэндэд онцлон анхаардаг сайн талууд байна. Энэ үйл ажиллагаа оюутнуудын төлөөллүүдийн уулзалт ярилцлагаар нотлогдлоо.

- Мөн НАССургуулийн төгсөх дамжааны оюутнууд нь 1-р дамжааны оюутнууддаа амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийдэг нь сайшаалтай байна. Эдгээр үзлэгийн үр дүнд амны хөндийн өвчлөлийн тохиолдлын хувь болон энэ талаар судалгааны ажил, амны хөндийн эрүүлжүүлэлт хийгддэггүй байна. Цаашдаа үзлэгийг өөрийн эмнэлэгт хийн эрүүлжүүлж, судалгааны ажил болгон оюутны болон багш нарын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих зэрэг ажлуудыг зохион байгуулвал үр дүнтэй ажил гэдгийг анхаарах хэрэгтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зорилтот бүлгийн оюутанд илүү анхаарч ажилладаг
- Оюутнуудыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулдаг
- Төгсөх ангийн оюутнууд шинэ элсэгч оюутнууддаа амны хөндийн үзлэг хийдэг

Анхаарах асуудал:

- Сургуулийн эрүүл мэндийн үзлэгийг даатгалд хамруулах
- Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг мэргэжилтэнтэй болох

Зөвлөмж:

- Ажил эрхлэгч оюутнуудын суралцах явцыг СБЗА байнга хянах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны сурч боловсрох үйл ажиллагааг дэмжин эрдэм шинжилгээ, судалгааны ажилд уриалах, эрдэм шинжилгээний хурлыг бусад оюутны байгууллагуудтай хамтран эрдмийн бага чуулганыг жил бүр зохион байгуулдаг нь оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээнүүдэд оролцуулах үйл ажиллагаанууд хангалттай зохион байгуулдаг нь харагдаж байна. Эдгээр уралдаан тэмцээнүүд зохион байгуулдаг календарчилсан төлөвлөгөөг үзэж баримтжууллаа. Мөн оюутны ёс зүй, хувь хүний хөгжлийн талаар нэр хүндтэй хүмүүсээр лекц уншуулах зэрэг нилээдгүй ажил зохион байгуулдаг нь тайланд дурьдагдсаны дагуу оюутнуудтай уулзсан асуумж хариултаар нотлогдлоо. Цаашдаа оюутнуудад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн шаардлагуудыг биелүүдэг зөв хандлага төлөвшүүлэх кредит хичээлийг сургалтанд албан ёсоор тусгах хэрэгтэйг ажил олгогчидтой хийсэн уулзалт ярилцалгаас анхааруулж байна.
- “Ач” АУИС нь Засгийн газрын 2016 оны 178 дугаар тушаалын дагуу “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр зөвхөн НАССургуулийн оюутнуудын 30% нь “Таван Богд Интернейшнл” ХХК-ны Номин сүлжээ дэлгүүрт амны хөндийн бүтээгдэхүүнийг танилцуулгыг хийдэг гэж тэмдэглэснийг тодруулахад бага цагаар сурлагын амжилтанд нөлөөлөхгүйгээр ажилладаг нь оюутнуудын ярианаас батлагдлаа.
- Ач АУИСургууль нь амжилттай суралцсан оюутнуудад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхээс гадна нэн ядуу, ар гэрийн гачигдалтай, бүтэн өнчин оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгодог нь сайшаалтай байна. Тус сургуулийн оюутнууд нь улсын хэмжээний тэтгэлэгт хөтөлбөрт өөрийн сургуулийн дэмжлэг тусалцаатайгаар хангалттай сайн хамрагддаг нь оюутнуудтай хийсэн

уулзалт ярианаас дүгнэхэд хангалттай гэж үзэж байна. Шинээр элссэн оюутнууд тангараг өргөдөг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шинээр элссэн оюутнуудаар оюутны тангараг өргүүлдэг

Анхаарах асуудал:

- Эмч эмнэлгийн ёс зүйн хичээлийг албан ёсоор сургалтын багц цагт нэмж оруулах

Зөвлөмж:

- Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг мэргэжилтэнтэй болох

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм журамтай. Захирлын 2015оны 028 тоот тушаалын дагуу “Ач АУИС-ийн Оюутны шилжилт хөдөлгөөний журмыг шинэчлэн батлуулан мөрдлөг болгон ажилладаг байна. Энэ журам нь 9 бүлэгтэй бөгөөд оюутнуудыг сургалтаас түр чөлөөлөх, улируулан суралцуулах, үргэлжлүүлэн суралцуулах, сургуулиас өөрийн хүсэлтээр гарах, суралцах эрхийг бүр мөсөн түтгэлзүүлэх, гадаад дотоодын их сургуулиудаас шилжин суралцах, мэргэжлийн чиглэлийг сольж суралцах, өмнөх шатны боловролын дипломоор дүйцүүлэн суралцуулах гэсэн үндсэн хэсэгтэй. Оюутны шилжилт хөдөлгөөний журмын дагуу шилжилт хөдөлгөөн хийх хүсэлт гаргасан оюутнуудын хүсэлт өргөдлийг оюутны алба хүлээн авч СБЗАлбаар дамжуулан холбогдох тооцоог гарган захиралд таницуулж шийдвэрлүүлэн захирлын тушаалаар баталгаажуулдаг байна. 2016-2020 он хүртэлх Оюутны шилжилт хөдөлгөөний журмын дагуух баримтууд, тоон үзүүлэлтүүдтэй танилцаж баталгаажууллаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шилжиж ирсэн оюутны тоо их

Анхаарах асуудал:

- Шилжин суралцах оюутны тоог тотмолжуулах

Зөвлөмж:

- Бусад мэргэжлийн салбаруудаас шилжин суралцах хүсэлтэй оюутны тоог элсэлттэй харьцуулан тоогтоож байх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн бичиг баримтыг Монгол улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайдын 2012 оны 01 сарын 02-ны өдрийн 01тушаалд үндэслэн “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу “Ач” АУИСургууль

нь Сургуулийн төгсөлтийн бичиг баримт буюу дипломын нууцлалыг уг тушаал дахь загварын дагуу сайжруулах зорилгоор Үндэсний үнэт цаасны хэвлэлээр баруун доод буланд нь тусгай нууцалсан дугаар, гэрлийн хугарлын нууцлалтайгаар хэвлүүлэхээс гадна баруун дээд буланд нь сургуулийн таних тэмдгийн нууцлал хийсэн нь төгсөлтийн дипломын үнэ цэн, нууцлалыг хангалттайгаар хадгалсан байна гэж дүгнэж байна.

- Сургалтын хөтөлбөрийн шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд төгсөлтийн шалгалтын мэргэжлийн зөвлөлийн шийдвэрт үндэслэн, захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг олгосныг гэрчлэх диплом, энгэрийн тэмдэг, эмчийн нэрийн тэмдэг олгодог үйл ажиллагаа нь тодорхой дэс дараалал тогтсон журмын дагуу явагддаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн дахин давтагдашгүй нууцлал бүхий диплом олгодог
- Онцгойлох диплом олгодог

Анхаарах асуудал:

- Сургуулийн дахин давтагдашгүй нууцлалтай тэмдэгийг чандлан хамгаалах

Зөвлөмж:

- Төгсөгчийн материалыг хадгалах архивлах, эмх цэгцийг улам сайжруулах

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа, багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа, багш нарт олгосон урамшууллын судалгаанаас харахад хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичигтэй нийцтэй байна.
- Багш суралцагчдын тооны харьцаа 2016 онд 1:26, 2017 онд 1:29, 2018 онд 1:24, 2019 онд 1:30, 2020 онд 1:26 байгаа нь зохистой гэж үзэж байна.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтоо биелүүлэхүйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.
- Багш нарын илүү цаг болон нэмэгдэл урамшууллын судалгаагаар 2016-2017 онд 42398945, 2017-2018 онд 68891094, 2018-2019 онд 62461181, 2019-2020 онд 44225707 байгаа нь тогтвортой бус байна гэж үзэж байна.
- Нүүр амны их эмчийн хөтөлбөр хэрэгжүүлэгч 56 багшийн 21% нь профессор, 9% дэд профессор, 29% нь ахлах багш, 30% нь багш, 11% нь дадлагажигч багш байгаа нь хүний нөөцийн бодлого зохистой харьцаанд байгааг илэрхийлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийг сонгон шалгаруулах болон багшлах үйл ажиллагаатай холбогдох эрх зүйн орчин маш сайн бүрдсэн
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа хийдэг

Анхаарах асуудал:

- Ач АУИС нь сургуулиа хөгжүүлэх мастер төлөвлөгөөгөө шинэчлэн алсын хараагаа тодорхойлж шинээр ашиглалтад орж байгаа сургуулийн эмнэлэгийн нөөц бололцоог сайжруулах үүднээс НАС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимүүдээ мэргэжлийн дагуу салган хөгжих бололцоогоор хангах
- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч мэргэжлийн тэнхмийн үндсэн багш нарын хувьд доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жинд анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Багшийн ажлын үнэлэмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ нийгмийн халамж үйлчилгээний хувьд бодитой дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг нэмэгдүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын хөгжлийн хэрэгцээ /Багшлахуйн ур чадвар, судалгааны болон мэргэжлийн ур чадвар/, Багш нарын мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаанаас харахад сүүлийн 3 жилээр багшийн хувь хүний хөгжил 25%, 37,5%, 39% болон өссөн, харин судалгааны арга зүйн хөгжил 75%, 67,7%, 54,5% болон буурсан үзүүлэлт харагдаж байна. Харин багшлах арга зүй, мэргэжлийн сургалтуудад хамрагдсан байдал нь өсөөд буураад сүүлийн жилд бага зэрэг өссөн үзүүлэлт байна.
- Багш бүхэн Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй. Хөтөлбөрүүдтэй нь тухайн сургууль дээр очиж ажилах үедээ танилцахад хөтөлбөртөө дүн шинжилгээ хийж өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ өгсөн байсан нь онцлог байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Багшийн хөгжлийн алба” 2013 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа
- Багшлах бүрэлдэхүүний сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн хүрээнд бэлтгэгдсэн байдал, цаашдын хөгжлийн хэрэгцээг тодорхойлдог судалгаа хийдэг
- Багш бүрийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй

Анхаарах асуудал:

- Багшийн бүрийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлтэд бодитой анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлж, багш нарыг богино, дунд хугацааны туршлага судлах, багш солилцооны хөтөлбөрт жигд хамруулах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- АЧ АУИС-ийн захирлын тушаалууд, үндсэн багш нарын бүтээлийн судалгаа, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлуудтай нэг бүрчлэн танилцахад мэргэжлийн тэнхимийн багш нарын ном товхимол-34, төсөлт ажил 17, гадаадад өгүүлэл-25, дотоодод өгүүлэл-100, гадаадад илтгэл-28, дотоодод илтгэл 114, патент-2, стандарт-4, удирдсан доктор-5, удирдсан магистр-29 байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дэлхийн нэр хүнд бүхий IF өндөр сэтгүүлүүдэд 8 өгүүлэл хэвлэгдсэн
- “Эрүүл монгол хүн” төслийн ажилд Ач АУИС-ийн НАС салбарын багш оюутнууд биечлэн оролцож, 1200 хүүхдийг эрүүлжүүлж, 22 сая төгрөгний ажил гүйцэтгэсэн

Анхаарах асуудал:

- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын үр дүнг мэргэжлийн хөтөлбөрт тусгах
- Эрдэм шинжилгээ судалгааны ажилд зарцуулах төсөв, биелэлтэд дүн шинжилгээ хийж ажиллах
- Мэргэжлийн тэнхимийн үндсэн багш нарын хувьд дэлхийн нэр хүнд бүхий IF өндөр сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэх байдал хангалттай биш байна.

Шаардлага:

- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч мэргэжлийн тэнхимийн үндсэн багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг мэргэжлийн хөтөлбөрүүдэд тусган ажиллах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Ач АУИС-ийн захирлын 2017.11.03-ны А/58 тоот тушаалын дагуу аттестатчиллын комисс байгуулагдан тус сургуулийн үндсэн багш нарын үйл ажиллагааг үнэлэх ажлыг 2019.2-р сараас 2019.03-р сарын хооронд зохион байгуулсан байна.
- Энэхүү аттестатчилалын үнэлгээгээр 5 ахлах багш дэд профессор 3 багш ахлах багшийн, 1 дадлагажигч багшаас багшийн шатлал руу шилжүүлэн ажиллуулсан.
- Мөн багшийн ажлын үнэлгээнд 70%-аас дээш үнэлэгдсэн, АУ-ны боловсрол судлалын сургалтад хамрагдсан багш нартаа БАГШЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ олгосон.

- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн 3 чиглэлээс гадна удирдлага-хамт олны үнэлгээ, оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ зэргийг нэгдсэн байдлаар гаргасан нь багшийн үйл ажиллагаанд 360 хэмийн үнэлгээ ашигласан нь шинэлэг, бодитой, олон талт үнэлгээ болж чадсан байна. Ийнхүү хичээлийн жил тутам 360 хэмийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог болжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын ажлыг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн
- Багшийн үйл ажиллагаанд 360 хэмийн үнэлгээ ашигладаг
- АЧ АУИС-д Багшлах эрхийн гэрчилгээ олгодог.
- Проф-багш нарын өөрийн үнэлгээний тайланг Cloud University системд оруулснаар багшийн үйл ажиллагааны баримт электрон хэлбэрт шилждэг

Анхаарах асуудал:

- Профессор багш нарын эрдэм шинжилгээний ажлын зардал бага байгаад анхаарах
- Профессор багш нарын тогтмол болон хувьсах цалингийн хоорондын харьцааг анхаарах

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн үнэлгээг бодитой байх дээр анхаарч ажиллах

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын бодлого, зохицуулалтын алба болон захиргаа, хяналт шинжилгээ, мониторингийн алба хамтран жил бүр чанарын баталгаажуулалтын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө гарган ажилладаг.
- Ач АУИС нь 2015 оны А/44 тоот тушаалаараа “Сургалтын технологи, чанарын хяналтын журам” батласан. Уг журмын дагуу тус сургуулийн сургалтын үйл ажиллагааны бүх түвшинд тогтмол үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд суурилсан нотолгоо бүхий дүгнэлт хийж, цаашид сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, чанарын баталгаажилтыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд Сургалтын бодлого, зохицуулалтын албанаас хяналт тавьж, холбогдох журмын дагуу арга хэмжээ авдаг
- Тус сургуулийн захирлын 2019 оны А/97 тоот тушаалаар Нүүр ам судлалын сургуулийн хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүн шинэчлэгдэн 7 хүний бүрэлдэхүүнтэй батлагдан ажиллаж байгаа
- “Ач” АУИС нь Хөтөлбөрийн үнэлгээг дараах түвшингүүдэд хийдэг. Үүнд:

Суралцагчдын сэтгэл ханамж
Төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага
Гүйцэтгэлийн
Үр нөлөөний

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлагагүй. Одоогоор “Сургалтын технологи, чанарын хяналтын журам” –ын дагуу үнэлгээ хийж ажиллаж байгаа.

Шаардлага:

- Чанарын баталгаажилтын талаар бодлого боловсруулж, журам батлаж хэрэгжүүлэх
- Чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлага боловсруулах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, сэтгэл ханамжийн талаарх судалгааг 1-3 жил тутам авдаг.
- 3 жил тутамд уг хөтөлбөрийн оролцогч талууд болох оюутан, багш, төгсөгч болон ажил олгогч нараас сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн дүгнэлт хийж үйл ажиллагаандаа тусгадаг.
- Ажил олгогчдын сэтгэл ханамж - 82,7%
- Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн 68,9%-тай байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хувийн сургуулийн нэг давуу тал нь төгсөгч, ажил олгогч, оюутны зүгээс ирсэн санал хүсэлтийг удирдах зөвлөлөөр хэлэлцэн материаллаг зүйлсийг авч шийдвэрлэх талд илүү шуурхай боломжтой байдаг нь харагдсан.
- Багш, оюутан, ажил олгогч, төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгааг авч үзэхэд бүх төгсөгчид ажил мэргэжилдээ сэтгэл ханамжтай байсан.

Анхаарах асуудал:

- Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдэд төгсөгч, ажил олгогч, оюутны төлөөллийг оруулан саналыг тусган ажиллах нь хөтөлбөрийг сайжруулахад нэг чухал нөлөөг үзүүлэх болно.

Зөвлөмж:

- Ажил олгогч болон төгсөгчдөөс ирсэн саналд оюутны ёс зүйн талд онцгойлон анхаарах, мөн төгсөлтийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, төгсөлтийн дараах тасралтгүй сургалтыг явуулах талд онцгой анхаарахыг зөвлөсөн. Мөн орчин үеийн ломбоны материал, шинэ техник, технологийн сургалтыг хийх зохион байгуулах шаардлагатай байгааг зөвлөсөн.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- 2019 оны “QS of world Universities Ranking” -аар Ач АУИС нь дэлхийн хэмжээнд 12503-т, 2016 оны Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд Монголын дээд боловсролын сургалтын байгууллагуудын дунд эрэмбэ, чансаа тогтоох арга зүй, зөвлөмж, судалгаагаар /АХБ Төслийн дугаар. 43007-023/ Монгол улсын нийт их сургуулиудын дунд 31-д эрэмблэгдсэн байна.
- Мэргэжлийн холбоод, нийгэмлэгүүдтэй хамтын ажиллагаа сайжирсан.
- Гадаадын ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудтай хамтын ажиллагаа дутмаг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Гадаад, дотоодын их дээд сургуулиудтай гэрээ байгуулан хамтран ажилласнаар шинэлэг арга туршлагаас суралцах, харилцан туршлага солилцох, залуу багш судлаачдаа суралцуулан эрдмийн зэрэг цолыг ахиулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талд анхаарч ажиллах хэрэгтэй.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	4.2		Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	3	6.3		Эрдэм шинжилгээ, судалгаа
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	7.1		Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт
Нийт		23	3		
Дүгнэлт		Бүрэн хангасан			

ДУГНЭЛТ

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Ач анагаах ухааны их сургуулийн сургуулийн “Нүүр ам судлал” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Ж.Үржинлхам

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Д.Уранчимэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Д.Энхцэцэг

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Сургалтын хөтөлбөрт хүүхэд, урьдчилан сэргийлэлтийн хичээлийн цагийг түлхүү оруулах ингэснээр бодит байдалд байгаа өвчлөлийг бууруулах, өвдсөн шүдний араас эмчлэх бус уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замыг заах нь чухал байна.
2. Багшийн ажлын үнэлэмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ нийгмийн халамж үйлчилгээний хувьд бодитой дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг нэмэгдүүлэх
3. Төгсөгчийн материалыг хадгалах архивлах, эмх цэгцийг улам сайжруулах
4. Оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
5. Цаашдаа номын сангийн үйлчилгээг олон улсын номын сангийн үйлчилгээний шаардлагад нийцүүлэх
6. Мэргэшүүлэх хичээл заадаг багш нарыг оюутан өөрсдөө сонгох боломжоор ханган олон оюутан сонгосон багшийг урамшуулан дэмжих.
7. Гадаад, дотоодын их дээд сургуулиудтай гэрээ байгуулан хамтран ажилласнаар шинэлэг арга туршлагаас суралцах, харилцан туршлага солилцох, залуу багш судлаачдаа суралцуулан эрдмийн зэрэг цолыг ахиулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талд анхаарч ажиллах.
8. Гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлж, багш нарыг богино, дунд хугацааны туршлага судлах, багш солилцооны хөтөлбөрт жигд хамруулах
9. Ажил олгогч болон төгсөгчдөөс ирсэн саналд оюутны ёс зүйн талд онцгойлон анхаарах, мөн төгсөлтийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, төгсөлтийн дараах тасралтгүй сургалтыг явуулах талд онцгой анхаарах. Мөн орчин үеийн ломбоны материал, шинэ техник, технологийн сургалтыг хийх зохион байгуулах төгсөгчдөө АЧ АУИС дээрээ давтан сургалтад хамруулах
10. Үйлчлүүлэгчдийн үзлэгийн картыг бүрдүүлэх, оюутнуудад амны хөндийн үзлэг хийсэн үр дүнгээ судалгааны ажил болгох

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Гарын үсэг
1	А. Мөнхдөл	Үндсэн багш	Нүүр амны мэс засал	88108471	
2	Т. Учрал	Үндсэн багш	Нүүр амны согог засал	88108840	
3	Г. Мөнхзул	Үндсэн багш	Нүүр амны эмчилгээ	99569529	
4	М. Майжаргал	Дадлагажигч багш	Нүүр амны согог засал	95957053	
5	Г. Ууганжаргал	Дадлагажигч багш	Хүүхдийн нүүр амны эмчилгээ	88096661	
6	Б. Мишээл	Дадлагажигч багш	Хүүхдийн нүүр амны эмчилгээ	99786375	
7	Ж. Дэчмаа	Тэнхимийн эрхлэгч	Дотрын өвчин судлал	99136441	
8	Н. Туяа	Ахлах багш	Сэтгэцийн өвчин судлал	99190538	
9	Б. Чимэглхам	Үндсэн багш	Мэдрэлийн өвчин судлал	94064361	

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Оюутны код	Курс	Сонгосон байдал	Утас	Гарын үсэг
1	Г. Саруул	dd17b003	501	Голч дүн 3.4	86050629	
2	У. Энхбаяр	dd18b112	501	Эрдэнэт (орон нутаг)	99915773	
3	Ө. Мөнхбаясгалан	dd17b036	502	5 курсын төлөөлөл	86192707	
4	Х. Болорцэцэг	dd17b028	504	Увс (орон нутаг)	96716600	
5	Э. Нандин-Эрдэнэ	dd18b011	401	НАСОЗ дэд тэргүүн	99572999	
6	Т. Анударь	dd18b033	403	Голч дүн 3.4	88776003	

№	Оюутны нэрс	Оюутны код	Курс	Сонгосон байдал	Утас	Гарын үсэг
7	А. Энхжин	dd18b048	403	Хүүхдийн нүүр ам судлалын оюутны клубын тэргүүн	90761626	
8	Т. Цогзолмаа	dd18b028	404	4 курсын дарга	95599121	
9	П. Ариунаа	dd18b130	405	4 курсын төлөөлөл	86868156	
10	Б. Оюундамба	dd19b052	405	4 курсын төлөөлөл	80346460	
11	Б. Энх-Эрдэнэ	dd19b004	301	Дотуур байр	94454717	
12	Б. Бат-Эрдэнэ	dd19b016	302	3 курсын төлөөлөл	95388839	
13	Г. Мядагмаа	dd20b047	204	2 курсын төлөөлөл	94988289	
14	Д. Отгон	dd20b049	204	2 курсын төлөөлөл	99 570901	
15	М. Тэргэл	dd21b026	102	1 курсын төлөөлөл	80688887	
16	Ц. Цэнгэл	dd21b027	102	1 курсын төлөөлөл	94749351	
17	Д. Пүрэвдулам	dd21b030	102	1 курсын төлөөлөл	95261025	

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	О. Болорцог	“Халиун толгой” нэгдсэн эмнэлэг, шүдний тасгийн эрхлэгч	89952626	
2	Б. Ариунаа	Ari's dent шүдний эмнэлэг, захирал	96042471	
3	н. Баясгалан	Саруул дент шүдний эмнэлэг, захирал	98116464	
4	н. Тэмүүжин	Mon family dent шүдний эмнэлэг, захирал	98979898	
5	н. Бат-Өлзий	Бүрэн дент шүдний эмнэлэг, захирал	99747424	
6	О. Батмагнай	Miracle шүдний эмнэлэг, захирал	99101144	
7	Ж. Цэнд-Өлзий	Их зайсан шүдний эмнэлэг, захирал	99100888	
8	Г. Сэлэнгэ	Dental sos захирал	99154018	
9	Б. Дэлгэржаргал	НШЭНТ, орлогч эрхлэгч	91090609	

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албантушаал	Утас	Гарын үсэг
1	Б. Алтантүлхүүр	2016	Crown med шүдний эмнэлэг, шүдний эмч	99652255	
2	М. Мядагмаа	2016	BB dent шүдний эмнэлэг, захирал	86114044	
3	Г. Төрбат	2016	Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, шүдний эмч	99232330	
4	Б. Очирхүү	2017	Туж дент шүдний эмнэлэг, шүдний эмч	80020216	
5	Б. Оюун-Эрдэнэ	2017	Эрхэс дент шүдний эмнэлэг, шүдний эмч	96017677	
6	Б. Цэрэннадмид	2017	“Инээд баясал” шүдний эмнэлэг	95559351	
7	Б. Номин	2018	Royal smile шүдний эмнэлэг, захирал	89403422	
8	М. Анужин	2019	Сайхан дент шүдний эмнэлэг, шүдний эмч	91651119	
9	Б. Тэгшзаяа	2020	Танан цагаан шүдний эмнэлэг, шүдний эмч	96966958	
10	Х. Хишигмаа	2020	Молор шүдний эмнэлэг, шүдний эмч	99595926	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



БМИҮЗ-д

Анагаах Ухааны Академийн Түшиц Байгууллага

**“АЧ” АНАГААХ УХААНЫ
ИХ СУРГУУЛЬ**

Улаанбаатар хот, СХД, 38-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө-11, Улаанбаатар 18101
Утас: 77119933, Факс: (976) 70172358
E-mail: info@ach.edu.mn, web: www.ach.edu.mn

2022-01-20 № 04

Санал хүргүүлэх нь

“Ач” АУИС-ийн сургалт эрхлэх 980122 тоот тусгай зөвшөөрлийн дагуу бакалавр зэрэгтэй нүүр амны их эмч бэлтгэх 5 жилийн, D091101 индекстэй “Нүүр ам судлал”-ын сургалтын хөтөлбөрт БМИҮЗ-өөр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, хэлэлцүүлэн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд зохих дүрэм журмын дагуу магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний тайлан бэлтгэн хүргэж, хөндлөнгийн шинжээчдэд тэдгээрийн илрэл нотолгоог газар дээр нь үзүүлэн танилцуулав.

БМИҮЗ-ийн шинжээчийн тайлантай танилцаж санал бүрэн нийлж байна.

ЗАХИРАЛ



Н.БААСАНЖАВ